




Дэлхийн өрсөлдөх чадварын 2016-2017 оны тайлан дахь Монгол Улсын зэрэглэлийг танилцуулж байна

Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ) жил бүр эрхлэн гаргадаг Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийнхаа дүнг 9 дүгээр сард дэлхий даяар танилцуулав. Өрсөлдөх чадварын индекс нь тухайн улсын хүрч чадах хөгжлийн түвшинг тодорхойлдог эдийн засгийн бүтээмжид нөлөөлөгч хүчин зүйлүүдийн үнэлгээнд үндэслэдэг юм. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тус тайлангийн дүнг улс орнууд анхааралтай авч үзэж бодлого, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлдэг ажээ. Монгол Улс 2005 оноос энэхүү тайланд нэгдэж, өрсөлдөх чадварын түвшингээ дэлхийн 140 гаруй оронтой харьцуулах боломжтой болсон юм.

Нээлттэй нийгэм Форум нь ДЭЗФ-ын түншээр 12 дахь жилдээ ажиллаж Өрсөлдөх чадварын тайлан дахь Монгол Улсын дүнг олон нийтэд өргөн хүрээнд танилцуулж ажилласнаар манай улсын төр засгийн зүгээс уг судалгааны дүнд анхаарал хандуулж, түүнийг бодлого шийдвэртээ ашиглаж байна. Тухайлбал, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030” бодлогын баримт бичгийн биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийн тоонд өрсөлдөх чадварын үзүүлэлт орсон нь судалгааны ач холбогдлыг улам нэмэгдүүлэв. Өнгөрсөн оны тайлангаар манай улс авбал зохих 7 онооноос 3,8 авч, судалгаанд хамрагдсан 140 орноос 104-рт эрэмбэлэгдсэн юм. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Монгол Улсын өнөөгийн түвшинг урагшлуулж, дэлхийд өрсөлдөх чадвар сайтай эхний 70 орны нэг болох зорилт дэвшүүлжээ.

Өрсөлдөх чадварын 2016-2017 оны тайлангаас харахад Монгол Улсын өрсөлдөх чадварт ахиц гарсангүй. Манай улс 3.8 оноо авсанаар судалгаанд хамрагдсан 138 орноос 102 дугаарт эрэмбэлэгдэж байгаа юм (Зураг 1).

Зураг 1. Монгол Улсын өрсөлдөх чадварын оноо, зэрэглэл, 2005-2016 он




Судалгаанд хамрагдаж эхэлснээс хойших 12 жилийн хугацаанд манай улс 3.2-3.9 оноо авсан нь өрсөлдөх чадварын хувьд дорвитой өөрчлөлт гарахгүй байгааг харуулж байна.

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форумын Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангууд дээр үндэслэн нэгтгэв.

Өрсөлдөх чадварыг тодорхойлогч 12 тулгуур үзүүлэлтээс Монгол Улс 4 үзүүлэлтээр бага зэрэг ахиц гаргажээ (Зураг 2). Өмнөх онтой харьцуулахад макро эдийн засгийн орчны үзүүлэлт 0,4 оноогоор өссөн бол санхүүгийн зах зээлийн хөгжил, технологийн бэлэн байдал, дээд боловсрол ба мэргэжлийн сургалт гэсэн үзүүлэлтүүд тус бүр 0,1 оноогоор өсөв. Технологийн бэлэн байдлын үзүүлэлтийн түвшний өсөлтөд үүрэн холбооны интернэт хэрэглэгчдийн тоо, интернэтийн хурд өссөн нь нааштай нөлөө үзүүлжээ.


Зураг 2. Монгол Улсын өрсөлдөх чадвар (12 тулгуур үзүүлэлтээр), 2015 ба 2016/2017 он



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форумын Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангууд үндэслэн нэгтгэв.

Макро эдийн засгийн орчны түвшин өсөхөд инфляци буурч 5,9% (110-р байр) болсон нь голчлон нөлөөлжээ (Зураг 3). ДНБ-д харьцуулсан улсын төсвийн тэнцэл -8,3% (125-р байр), Засгийн газрын өр 76,5% (110-р байр) байгаа бол үндэсний нийт хуримтлал 21,7% (59-р байр) байна. Ерөнхийд нь авч үзвэл, манай улсын макро эдийн засгийн орчны үзүүлэлт 2013 оноос эхлэн бууралттай байгаа юм.

Зураг 3. Макро эдийн засгийн орчин



Макро эдийн засгийн орчинг тодорхойлогч үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Оноо (7 онооноос)		Өөрчлөлт
	2015-2016	2016-2017	
3-р тулгуур: Макро эдийн засгийн орчин	3,2	3,6	0,4
3.1. Улсын төсвийн тэнцэл (ДНБ-д харьцуулсан %)*	-11	-8,3	2,7
3.2. Үндэсний нийт хуримтлал (ДНБ-д харьцуулсан %)*	24,3	21,7	-2,6
3.3. Инфляци (жилийн % өөрчлөлт)*	12,9	5,9	-7
3.4. Засгийн газрын өр (ДНБ-д харьцуулсан %)*	76,5	76,5	0

Харин өрсөлдөх чадварын 4 тулгуур үзүүлэлтийн түвшин буурчээ. Тухайлбал, бизнесийн боловсронгуй байдал, бараа бүтээгдэхүүний зах зээлийн үр ашигтай байдал, хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай байдал тус бүр 0,2 оноогоор, институциудын чанар 0,1 оноогоор буурчээ. Өрсөлдөх чадварыг тодорхойлогч 12 тулгуур үзүүлэлтээс дэд бүтэц, санхүүгийн зах зээлийн хөгжил, инноваци, бизнесийн боловсронгуй байдал зэрэг 5 үзүүлэлтээр авбал зохих онооны 50 хувьд ч хүрч чадаагүй байна.

Өрсөлдөх чадварын индексийн 12 тулгуур үзүүлэлтийг бүрдүүлдэг 115 дэд үзүүлэлтээс манай улс 140-өөд орноос 10 гаруй үзүүлэлтээр эхний 50 байрт багтсан нь тэмдэглүүштэй юм. Эдгээрээс дурдвал, цалин хөлс тогтоох уян хатан байдал (4-р байр), хөрөнгө оруулагчийн хамгаалалт (8-р байр), интернэтийн хурд (17-р байр), ажлаас халахад гарах зардал (19-р байр), татварын нийт хувь хэмжээ (23-р байр), үүрэн холбооны интернет хэрэглэгчдийн тоо (32-р байр), их дээд сургуульд хамрагдалт (38-р байр), математик, шинжлэх ухааны боловсролын чанар (40-р байр), бизнес эхлэн эрхлэхэд шаардагдах журмын тоо (41-р байр), эрдэмтэд, инженерүүдийн хүрэлцээ, хангамж (47-р байр) зэрэг болно.

Зүүн Ази, номхон далайн бүсийн хөгжиж буй орнуудтай харьцуулахад манай улс эрүүл мэнд, бага боловсрол, дээд боловсрол, мэргэжлийн сургалт, хөдөлмөрийн зах зээлийн үр ашигтай байдал, технологийн бэлэн байдал гэсэн үзүүлэлтүүдээр давуу байна. Харин дэд бүтэц, санхүүгийн зах зээлийн хөгжил, макро эдийн засгийн орчин зэрэг үзүүлэлтүүдээр тэдгээр орнуудаас доогуур түвшинд байна.

Өрсөлдөх чадварын индексийг тооцохдоо статистик мэдээ болон тухайн улсын Бизнесийн удирдах ажилтнуудын санал асуулгын дүнг ашигладаг. Бизнесийн удирдах ажилтнуудын санал асуулгын дүнд үндэслэн тухайн улсад бизнес эрхлэхэд саад болж буй гол хүчин зүйлсийг мөн тодорхойлон гаргадаг. 2016 оны судалгаагаар Монгол улсад бизнес эрхлэхэд саад учруулж буй хүчин зүйлсэд засгийн газрын тогтворгүй байдал, санхүүжилт авах боломж, гадаад валютын зохицуулалт, бодлогын тогтворгүй байдал, төрийн хүнд суртал зэрэг үзүүлэлтүүд багтсан байна.



Өндөр хөгжилтэй орнууд болох Швейцар, Сингапур, АНУ, Герман, Нидерланд, Швед зэрэг улсууд өрсөлдөх чадвараараа дэлхийд тэргүүлж байна. Эдгээр орнуудын хувьд төрийн институциудын үр ашигтай, ил тод байдал, макро эдийн засгийн орчин, боловсролын чанар, бизнесийн төгөлдөршил, инноваци гаргах чадвар өндөр байна. Манай урд хөрш Хятад улс 4.95 оноогоор 28-рт, хойд хөрш Орос улс 4.51 оноогоор 43-рт эрэмблэгдсэн байна.

Эцэст нь дүгнэхэд, Монгол Улс өрсөлдөх чадварын хувьд авбал зохих онооноос дөнгөж талаас илүү хувийг авсан нь өрсөлдөх чадварыг дээшлүүлэх талаар дорвитой ахиц гаргах шаардлагатай байгааг харуулж байна. Ялангуяа институциудын чанар, дэд бүтэц болон санхүүгийн зах зээлийн хөгжил гэсэн үзүүлэлтүүдийг сайжруулахад нэн тэргүүнд анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Өрсөлдөх чадварын индексийн дүн нь засгийн газар, бизнесийн болон иргэний нийгмийн байгууллагуудын дунд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэхэд зохих хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

Дэлхийн өрсөлдөх чадварын 2016-2017 оны тайланг бүрэн эхээр нь <https://www.weforum.org/reports> хуудаснаас үзнэ үү.

Хариуцсан ажилтан: Эдийн засгийн бодлогын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам
Утас:313207